



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/61

Чойр

Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.13, Согтууруулах ундааны эрэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15¹ дүгээр зүйлийн 15¹.4, 40 дүгээр зүйлийн 40.9, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сүмбэр сумын Найрамдал багт байрлах “Тэлмүүн хурд” ХХК-ийн “White house” ресторанд сул болон өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 2029 оны 02 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай.

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгүүдэд тавигдах нөхцөл шаардлагыг бүрэн хангаж ажиллахыг “Тэлмүүн хурд” ХХК-ийн захирал Ц.Бямбалхамд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Нэргүйцэцэг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Хонгор), Цагдаагийн хэлтсийн дарга (хурандаа Ц.Баярхүү), Эрүүл мэндийн газрын дарга (Ц.Мөнх-Од), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Э.Түвшинзаяа), Татварын хэлтсийн дарга (П.Энх-Оюун), Нийгмийн даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Байгальсайхан), Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Жамбаасүрэн) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4180400134

138400134